

**ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК**

16 тоот, 14 давхар, Моннис цамхаг,
Чингисийн өргөн чөлөө 15, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14240
Утас/Факс: (976) 7007 8085, Цахим хуудас: www.eot.mn

2024.08.14 № 01/164

танай _____-ны № _____-т

Тодруулга №2-т хариу хүргүүлэх тухай

1. Энэхүү тендер нь манай улсын дотоодын тендер бөгөөд гадаадын хуулийн этгээд тус тендерт оролцохыг хориглоогүй. Тухайлбал: ТШЗ-ын В. Тендер бэлтгэх хэсэгт “Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд...” гэж бүх шаардлагуудад тодотгосон байна. Ийм учраас тус ТШЗ-ын шаардлагуудыг тендерт оролцож буй дотоодын болон гадаадын бие даасан этгээдүүд эсвэл түншлэн оролцож байгаа талуудад нэгэн адил биелүүлэх ёстой гэж ойлгож байна. Харин туслан гүйцэтгэгч байгууллагуудын (хувь хүн) хувьд эдгээр шаардлагууд тавигдахгүй гэж ойлгож болох уу. Үүнийг тодруулж өгнө үү?

Хариулт:

- а) ТШЗ-ын 17.4 “...Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн техникийн чадавх болон туршлагын шаардлага ТШЗ 19.1-д заасан чадавхын болон туршлагын шаардлагын 40-өөс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байх шаардлагатай.” гэж заасны дагуу тендерт оролцож буй дотоодын болон гадаадын этгээдүүд болон түншлэн оролцож байгаа талуудад нэгэн адил хангана.
- б) Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.4-т “Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно.”, 17.6-д “Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхээр гэрээнд заасан үүргийг гүйцэтгэхэд энэ хуулийн 15.5-д зааснаар зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардах бол туслан гүйцэтгэгч энэ шаардлагыг хангасан байна.” болон ТШЗ-ын 17.5-д “Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.” гэж заасны дагуу шаардана.

/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./ гэсэн шаардлага туслан гүйцэтгэгч гадаадын этгээдэд мөн адил хамаарна.

2. ТШЗ 19.1-ийн 3-д ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана” “Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагатай байна. Ижил төстэй ажил гэдэгт усан сан, алсын зайд ус дамжуулах шугам болон усан цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагыг тооцно” гэсэн байгаа. Энэ заалтын “...алсын зайд ус дамжуулах шугам” гэдэг заалтад 50 км-ээс хол зайд ус дамжуулж байгаа томоохон шугам хоолой, насос танцууд, усан сангууд бүхий ус хангамжийн системийн (энэхүү тендерийн нэг том багц хэсэг бол ус хангамжийн системийн барилга байгууламж байгаа) ажлын зураг төсөл хийсэн туршлага орох уу. Үүнийг тодруулж өгнө үү?

Хариулт: Ижил төстэй ажилд “... алсын зайд ус дамжуулах шугам” гэдэг заалтад танайхаас ирүүлсэн 50 км-ээс хол зайд ус дамжуулж байгаа шугам хоолой, насос станцууд, усан сангууд бүхий ус хангамжийн системийн ажлын зураг төсөл хийсэн туршлагыг усан сан, алсын зайд ус дамжуулах шугам болон усан цахилгаан станцын ТЭЗҮ-ийн аль нэгийг боловсруулж, батлуулж байсан туршлага шаардлагатай бөгөөд танай тодруулгад дурдсан зураг төсөл хийсэн туршлагыг хамтад нь ирүүлсэн үед тооцно. Харин дангаар нь ирүүлсэн үед ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагад тооцохгүй.

3. 1. Тендерийн бичиг баримтын ТШЗ 19.1-ийн 1-д хүний нөөцийн шаардлага нь Ажлын даалгаврын 7.1-д ТЭЗҮ боловсруулах зөвлөх багийн голлох мэргэжилтнүүдийн оролцоотой өөр өөр байгаа тул бид ТШЗ буюу тендерийн бичиг баримтыг гол үндэслэл болгож байгаа тул үүнийг тодруулж өгнө үү?
2. Мөн дараах хүснэгтийн 15 ба 16-д нэг төрлийн мэргэжилтнийг хоёр өөр мэргэжилтэн мэтээр салгаж өгсөн бөгөөд энэ хүснэгтийн доод талд “Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн:” хэсэгт мөн тус тусад нь салгаж өгснийг нэгтгэж нэг үндсэн ажилтан байж болохыг тодруулж өгнө үү?

ТШЗ.19.1-д		АД-ын 7 хүснэгтэд	
7. Эдийн засагч	1 хүн	Байгалийн баялгийн эдийн засагч	2 хүн, (Гадаад 1, дотоод 1)
8. Төсөвчин	1	-	-
10. Хуульч	1	Хуульч	2 (гадаад 1, дотоод 1)
15. Усан сан төлөвлөлтийн инженер	1	Усан сан төлөвлөлтийн инженер	2 (гадаад 1, дотоод 1)
16. Боомт болон ус хуримтлуулах сангийн төлөвлөлтийн инженер	2	Боомтын зураг төслийн инженер	1 (гадаад)

Хариулт:

- 3.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу тендерийн баримт бичгийг боловсруулсан бөгөөд зөвлөх багийн голлох мэргэжилтнүүдийг ТШЗ 19.1-д заасны дагуу ирүүлнэ.
- 3.2 Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-ийн Усан сан төлөвлөлтийн инженер нь усыг алсын зайд дамжуулах өргөлтийн насос станцын усан санг төлөвлөх, Боомт болон ус хуримтлуулах сангийн төлөвлөлтийн инженер нь Боомт бүхий усан сангийн төлөвлөлтийг гүйцэтгэх зорилгоор тус тус шаардсан. Уг хоёр мэргэжилтэн нь 1 үндсэн ажилтан байх боломжгүй бөгөөд тус бүр үндсэн ажилтан байна.

4. Ажлын даалгаврын 4.3.8-д “Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 сарын 08 өдрийн 58 дугаар тогтоол Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний журмын дагуу Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх” гэж заасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь Байгаль орчны ерөнхий үнэлгээг үндэслэн хийгддэг бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар баталгаажсан зураг төсөл, ТЭЗҮ-д үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргадаг. Иймд манай ТЭЗҮ-ийг батлагдсаны дараа байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдэх ёстой учраас бид энэхүү ажлын хүрээнд олон улсын жишгийн дагуу Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний эхний шат буюу урьдчилсан үнэлгээ хийх эсэхийг тодруулж өгнө үү.

Хариулт: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт, тухайн сум, дүүргийн Засаг даргын санал болон холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлэн энэ хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэнэ.” гэж заасан зохицуулалтыг баримтлах бөгөөд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийж ирүүлэх шаардлагагүй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ХХК
ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ГАНХҮҮ